



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/236

Дэлгэрмөрөн

「 Хэмжих хэрэгсэл, шалгалт тохируулга, бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын үнэлгээг хамтран зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, баталгаажуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2, Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 27 дүгээр зүйлийн 27.2.1 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн А/236 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэмжих хэрэгсэл, шалгалт тохируулга, бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын үнэлгээг хамтран зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Нархүү (Тамгын газрын дарга)

Гишүүдэд: Ч.Бямбадорж (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

С.Ганбат (Мал эмнэлгийн улсын байцаагч)

Ш.Сэр-Од (Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга)

С.Очирбат (Дэлгэрмөрөн 5 дугаар багийн Засаг дарга)

2. Тохирлын үнэлгээг 2022 оны 04 дүгээр сарын 27-ний өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 26-ний өдрүүдэд стандарт хэмжилзүйн хэлтсийн мэргэжилтэн, улсын байцаагч нартай хамтран чанартай хийж гүйцэтгэхийг ажлын хэсгийн ахлагч гишүүдэд

3. Аж ахуйн нэгж байгууллага худалдаа үйлчилгээний цэг салбарыг тохирлын үнэлгээнд бүрэн хамруулж тохирлын үнэлгээ, хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулга хийхэд шаардагдах ажлын өрөө байр туслах ажилтныг томилон ажиллахыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

642201049

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА *Сумъяабазар* С.СУМЪЯАБАЗАР

